

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 08 ДУГААР САРЫН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**


2025 оны 09 дүгээр сарын 08

Улаанбаатар хот

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангах зорилгоор байгууллагын үйл ажиллагааны 05 дугаар сарын биелэлтэд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-д заасны дагуу төлөвлөгөөнд тусгагдсан 2 зорилтын 22 арга хэмжээг хамруулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Арга хэмжээний 45.4 хувь нь бүрэн хангалттай буюу 100 хувь, 50 хувь нь хангалттай буюу 85 хүртэл, 4.5 хувь нь хангалтгүй буюу 70 хүртэл хувьтай үнэлэгдлээ. (График 1, Хүснэгт 1)

График 1



Хүснэгт 1


Нийт арга хэмжээ	Арга хэмжээний зорилт, хэрэгжилтийн үнэлгээ (хувиар)			Хувь
	Бүрэн хангалттай	Хангалттай	Хангалтгүй	Дундаж хувь
	100 хүртэл	85 хүртэл -70-с дээш	70 хүртэл	
1	2	3	4	6
22	10	10	2	88.6

Зорилт тус бүрээр ангилан авч үзвэл Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна” зорилтод тусгагдсан 8 арга хэмжээний дундаж “хангалттай” буюу 80 хувийн биелэлттэй, Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ” зорилтод тусгагдсан 14 арга хэмжээнүүдийн дундаж үнэлгээ нь “бүрэн хангалттай” буюу 93.5 хувьтай байна. (График 2, Хүснэгт 2)

Хүснэгт 2

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	85%	70%	50%	30%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна	8	1	6	-	-	1	80
2	Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ	14	9	4	1	-	-	93.5
Нийт		22	10	10	1	-	1	86.7

График 2



Чиглэл тус бүрээр авч үзвэл газар, нэгжүүд байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр байгууллагын үйл ажиллагааны сарын төлөвлөгөөнд тусгуулаагүй үндсэн чиг үүргийн ажлыг тогтмол гүйцэтгэж байгаа нь үнэлгээ буурч байгаа шалтгаан юм. Иймд газар, нэгжүүд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хугацааны дагуу төлөвлөх, үр дүнг нэмэгдүүлж, эрчимжүүлэх шаардлагатай.

Хүснэгт 3

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	85%	70%	50%	30%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Захиргаа, удирдлагын газар	6	4	2	-	-	-	95
2	Виз, зөвшөөрлийн газар	2	-	2	-	-	-	85
3	Иргэний харьяаллын газар	1	-	1	-	-	-	85

1	2	3	4	5	6	7	8	9
4	Зөрчил шалган шийдвэрлэх газар	3	1	2	-	-	-	90
5	Санхүү, хангалт, үйлчилгээний газар	1	1	-	-	-	-	100
6	Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтэс	2	1	1	-	-	-	92.5
7	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс	2	1	1	-	-	-	92.5
8	Мэдээллийн технологийн хэлтэс	2	1	-	-	-	1	65
9	Зөвлөгөө, мэдээллийн хэлтэс	1	-	1	-	-	-	85
10	Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	1	-	-	-	-	100
11	Санхүү, хангалт, үйлчилгээний газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	-	-	1	-	-	70
Нийт		22	10	10	1	-	1	87.2

График 3



Мөн газар хэлтсүүдийн буюу Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан 1 арга хэмжээ 100 хувь, Санхүү, хангалт, үйлчилгээний газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан 1 арга хэмжээний биелэлт 70 хувьтай үнэлэгдсэн байна.

Дүгнэлт, зөвлөмж

Байгууллагын 2025 оны 08 дугаар сард төлөвлөн гүйцэтгэсэн 22 арга хэмжээний хэрэгжилт 88.6 хувьтай үнэлэгдлээ. Энэ нь өмнөх сарын үйл ажиллагааны үнэлгээнээс 10.4 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд үнэлгээ буурсан арга хэмжээнүүдийн үр дүнг сайжруулж, хяналт-шинжилгээгээр өгсөн дүгнэлт, зөвлөмжийн дагуу газар, нэгжүүд эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээг тайлагнаж, хэрэгжүүлэх шаардлагатай юм. Үүнд:

1. “Хангалтгүй” буюу 70 хүртэл хувьтай үнэлэгдсэн:

Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан системийг сайжруулах, систем хооронд дата хөрвүүлэх (хэрэгжилт 30 хувь)

-Мэдээллийн технологийн хэлтэс шалгуур үзүүлэлтэд тусгагдсан системүүдийн өгөгдлийн сангийн датаг хөрвүүлж, системийн үйл ажиллагааг бүрэн сайжруулж, зорилтод түвшиндээ хүрч ажиллах;

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, тоон мэдээлэлд хяналт тавих (хэрэгжилт 70 хувь)

- Санхүү, хангалт үйлчилгээний газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан тус арга хэмжээ нь зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй тул зохион байгуулалт, хяналт, хариуцлагыг нэмэгдүүлэх;

2. “Хангалттай” буюу 70-85 хүртэл хувьтай үнэлэгдсэн:

85 хувьтай үнэлэгдсэн нийт 10 арга хэмжээ нь байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан тухайн газар, нэгжийн үндсэн чиг үүргийн ажил бөгөөд 2025 оны жилийн эцсийн үнэлгээ гараагүй тул бүрэн хангагдсан гэж үзэхгүй болно. (хэрэгжилт 85 хувь)

3. “Бүрэн хангалттай” буюу 100 хувьтай үнэлэгдсэн 11 арга хэмжээний үр дүнг цаашид бууруулахгүйгээр чанаржуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.

Мөн байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний нэгдүгээр зорилгын “Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна”, хоёрдугаар зорилгын “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ” зорилтуудад тусгагдсан арга хэмжээнүүдийг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган үр дүнг нэмэгдүүлж ажиллахыг зөвлөмж болгож байна.